

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: УВА-2026/020/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Т.Амармэнд

Утас: 70453799, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

### **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

### **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
  - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
  - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
  - 3.5.3 Нэмэлт төсөв

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
  - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
  - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
  - 4.5.1 Завсрын аудитын талаар
  - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

#### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН СОЁЛЫН  
ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.ЗАЯАХҮҮ ТАНАА

2026.02.25 № УВА-2026/020/НА-СА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Улаангом сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Улаангом сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050214

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М. БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>31,383,083.12</b>	<b>36,960,694.06</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,466,883.12</b>	<b>2,314,494.06</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	375,429.12	125,429.12
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>1,091,454.00</b>	<b>2,189,064.94</b>
3351	Байгууллагаас авах авлага	1,091,454.00	2,189,064.94
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>29,916,200.00</b>	<b>34,646,200.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>4,000,000.00</b>	<b>4,000,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	4,000,000.00	4,000,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>25,916,200.00</b>	<b>30,646,200.00</b>
35410	Бичиг хэргийн материал	246,400.00	135,000.00
35420	Аж ахуйн материал	793,500.00	2,664,900.00
35450	Барилгын засварын материал	5,000.00	5,000.00
35470	Бусад хангамжийн материал	24,871,300.00	27,841,300.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>607,757,902.79</b>	<b>598,618,223.97</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>607,757,902.79</b>	<b>598,618,223.97</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>582,860,902.79</b>	<b>574,001,723.97</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	618,100,100.00	618,100,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-84,176,478.64	-90,805,120.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,552,487.50	116,220,287.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-86,614,844.03	-91,939,926.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,165,250.00	14,165,250.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,610,970.04	-9,184,225.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,400,000.00	2,400,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,400,000.00	-2,400,000.00
39217	Ном	17,445,358.00	17,445,358.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>24,897,000.00</b>	<b>24,616,500.00</b>
39301	Программ хангамж	1,061,000.00	1,061,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-780,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	24,336,000.00	24,336,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>639,140,985.91</b>	<b>635,578,918.03</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>69,954.83</b>	<b>671,743.92</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>69,954.83</b>	<b>671,743.92</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>69,954.83</b>	<b>671,743.92</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	605,743.92
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>69,954.83</b>	<b>66,000.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	69,954.83	66,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>639,071,031.08</b>	<b>634,907,174.11</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>639,071,031.08</b>	<b>634,907,174.11</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	639,621,454.00	639,621,454.00
51101	Өмч: - төрийн	639,621,454.00	639,621,454.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-73,622,453.22</b>	<b>-77,786,310.19</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-73,622,453.22	-73,622,453.22
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-4,163,856.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	73,072,030.30	73,072,030.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>639,140,985.91</b>	<b>635,578,918.03</b>

## 2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	302,522,594.95	286,322,487.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	244,844,394.95	14,496,887.24
120	Нийтлэг татварын бус орлого	14,625,000.00	14,496,887.24
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	14,625,000.00	14,496,887.24
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,075,000.00	2,822,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	11,674,387.24
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	3,550,000.00	0.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	230,219,394.95	0.00
122005	Төсвөөс санхүүжих	230,219,394.95	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,678,200.00	271,825,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,900,000.00	0.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөнөөс	6,900,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,778,200.00	37,955,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,778,200.00	37,955,800.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	233,869,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	233,869,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	297,736,113.20	290,486,344.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	297,736,113.20	290,486,344.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,530,682.74	250,021,690.67
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	149,862,242.38	162,082,485.45
210101	Цалин	149,862,242.38	125,904,465.45
210102	Нэмэгдэл цалин	0.00	33,675,420.00
210104	Урамшуулал	0.00	2,502,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,581,139.34	19,475,333.99
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,631,338.30	13,642,928.63
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,570,669.99	1,429,948.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	711,418.77	706,868.61
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	711,418.77	727,648.11
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,956,293.51	2,967,940.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,848,152.58	43,302,232.41
210301	Гэрэл цахилгааны зардал	1,454,581.38	908,709.21
210302	Түлш, халаалтын зардал	42,393,571.20	42,393,523.20
2104	Хангамж, бараа материалын зардал	5,171,993.43	2,935,700.00
210401	Бичиг хэргийн материал	1,858,050.00	563,700.00
210402	Тээвэр, шатахууны зардал	999,922.25	286,300.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	950,021.18	461,500.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	165,000.00	0.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,199,000.00	1,624,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,235,150.00	5,954,100.00
210601	Багаж хэрэгсэл	0.00	370,000.00
210602	Тавилга	150,000.00	0.00

210604	Урсгал засвар	6,085,150.00	5,584,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,402,450.00	705,000.00
210702	Дотоод томилолтын зардал	2,402,450.00	705,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	9,511,818.00	1,239,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,509,458.00	780,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	0.00	216,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,759,000.00	0.00
210807	Газрын төлбөр	243,360.00	243,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,917,737.01	14,327,478.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	183,000.00	1,440,000.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	0.00	80,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,734,737.01	12,807,478.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,205,430.46	40,464,653.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,454,080.00	31,584,395.83
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	620,400.00	1,280,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,053,680.00	30,304,395.83
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	780,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,751,350.46	8,880,257.71
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,751,350.46	8,880,257.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	4,786,481.75	-4,163,856.97
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	4,786,481.75	-4,163,856.97

### 2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ		Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	231,853,500.00	227,838,842.29	4,014,657.71	98.3
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	231,853,500.00	227,838,842.29	4,014,657.71	98.3
210	Бараа, үйлчилгээний зардал	200,204,200.00	196,198,942.29	4,005,257.71	98.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,889,400.00	161,576,055.46	1,313,344.54	99.2
210101	Үндсэн цалин	98,939,400.00	99,938,129.01	(998,729.01)	101.0
210102	Нэмэгдэл	54,416,800.00	55,666,939.28	(1,250,139.28)	102.3
210104	Урамшуулал	9,533,200.00	5,970,987.17	3,562,212.83	62.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,361,200.00	20,168,126.83	193,073.17	99.1
210201	Тэтгэврийн даатгал	13,891,500.00	13,843,322.16	48,177.84	99.7
210202	Тэтгэмжийн даатгал	1,617,400.00	1,594,341.81	23,058.19	98.6
210203	ҮОМШӨ ний даатгал	808,700.00	797,170.90	11,529.10	98.6
210204	Ажилгүйдлийн даатгал	808,700.00	779,613.73	29,086.27	96.4
210205	Эрүүл мэндийн даатгал	3,234,900.00	3,153,678.23	81,221.77	97.5
2104	Хангамж, бараа материалын зардал	2,320,200.00	2,263,200.00	57,000.00	97.5
210401	Бичиг хэрэг	460,000.00	363,800.00	96,200.00	79.1
210402	Тээвэр (шатахуун)	300,000.00	286,300.00	13,700.00	95.4
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	545,500.00	354,500.00	60.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	660,200.00	1,067,600.00	(407,400.00)	161.7
2106	Эд хогшил худалдан авах	5,308,300.00	4,938,200.00	370,100.00	93.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,438,300.00	4,437,800.00	500.00	100.0
210604	Урсгал засвар	870,000.00	500,400.00	369,600.00	57.5
2107	Томилолт, зочны зардал	750,000.00	705,000.00	45,000.00	94.0
210702	Дотоод албан томилолт	750,000.00	705,000.00	45,000.00	94.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,643,400.00	2,983,360.00	1,660,040.00	64.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,250,000.00	2,590,000.00	1,660,000.00	60.9
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	150,000.00	150,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	243,400.00	243,360.00	40.00	100.0

2201	Бараа үйлчилгээний бусад зардал	3,931,700.00	3,565,000.00	366,700.00	90.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,831,700.00	3,485,000.00	346,700.00	91.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	80,000.00	20,000.00	80.0
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,649,300.00	31,639,900.00	9,400.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,649,300.00	31,639,900.00	9,400.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,289,400.00	1,280,000.00	9,400.00	99.3
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,359,900.00	30,359,900.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	237,352,900.00	227,838,842.29	9,514,057.71	96.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	235,119,900.00	226,355,442.29	8,764,457.71	96.3
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / улсын төсөв/	235,119,900.00	226,355,442.29	8,764,457.71	96.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,233,000.00	1,483,400.00	749,600.00	66.4
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,233,000.00	1,483,400.00	749,600.00	66.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	7.00	7.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.0

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2014 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	639,621,454.00	73,072,030.30	-78,817,210.31	00.00	633,876,273.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>639,621,454.00</b>	<b>73,072,030.30</b>	<b>-78,817,210.31</b>	<b>00.00</b>	<b>633,876,273.99</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	13,317,969.33	00.00	13,317,969.33
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>639,621,454.00</b>	<b>73,072,030.30</b>	<b>-73,622,453.22</b>	<b>00.00</b>	<b>639,071,031.08</b>
D01	<b>2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>639,621,454.00</b>	<b>73,072,030.30</b>	<b>-73,622,453.22</b>	<b>00.00</b>	<b>639,071,031.08</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>639,621,454.00</b>	<b>73,072,030.30</b>	<b>-73,622,453.22</b>	<b>00.00</b>	<b>639,071,031.08</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,163,856.97	00.00	-4,163,856.97
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>639,621,454.00</b>	<b>73,072,030.30</b>	<b>-77,786,310.19</b>	<b>00.00</b>	<b>634,907,174.11</b>

## 2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	231,853,500.00	225,853,842.29	5,999,657.71	97.41
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	231,853,500.00	225,853,842.29	5,999,657.71	97.41
210	Бараа, үйлчилгээний зардал	200,204,200.00	194,213,942.29	5,990,257.71	97.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,889,400.00	161,576,055.46	1,313,344.54	99.19
210101	Үндсэн цалин	98,939,400.00	99,938,129.01	(998,729.01)	101.01
210102	Нэмэгдэл	54,416,800.00	55,666,939.28	(1,250,139.28)	102.30
210104	Урамшуулал	9,533,200.00	5,970,987.17	3,562,212.83	62.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,361,200.00	20,168,126.83	193,073.17	99.05
210201	Тэтгэврийн даатгал	13,891,500.00	13,843,322.16	48,177.84	99.65
210202	Тэтгэмжийн даатгал	1,617,400.00	1,594,341.81	23,058.19	98.57
210203	ҮОМШӨ ний даатгал	808,700.00	797,170.90	11,529.10	98.57
210204	Ажилгүйдлийн даатгал	808,700.00	779,613.73	29,086.27	96.40
210205	Эрүүл мэндийн даатгал	3,234,900.00	3,153,678.23	81,221.77	97.49
2104	Хангамж, бараа материалын зардал	2,320,200.00	2,263,200.00	57,000.00	97.54
210401	Бичиг хэрэг	460,000.00	363,800.00	96,200.00	79.09
210402	Тээвэр (шатахуун)	300,000.00	286,300.00	13,700.00	95.43
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	545,500.00	354,500.00	60.61
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	660,200.00	1,067,600.00	(407,400.00)	161.71
2106	Эд хогшил худалдан авах	5,308,300.00	4,938,200.00	370,100.00	93.03
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,438,300.00	4,437,800.00	500.00	99.99
210604	Урсгал засвар	870,000.00	500,400.00	369,600.00	57.52
2107	Томилолт, зочны зардал	750,000.00	705,000.00	45,000.00	94.00
210702	Дотоод албан томилолт	750,000.00	705,000.00	45,000.00	94.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,643,400.00	2,983,360.00	1,660,040.00	64.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,250,000.00	2,590,000.00	1,660,000.00	60.94
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	150,000.00	150,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	243,400.00	243,360.00	40.00	99.98

2201	Бараа үйлчилгээний бусад зардал	3,931,700.00	1,580,000.00	2,351,700.00	40.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,831,700.00	1,500,000.00	2,331,700.00	39.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	80,000.00	20,000.00	80.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,649,300.00	31,639,900.00	9,400.00	99.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,649,300.00	31,639,900.00	9,400.00	99.97
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,289,400.00	1,280,000.00	9,400.00	99.27
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,359,900.00	30,359,900.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	237,352,900.00	227,838,842.29	9,514,057.71	95.99
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	235,119,900.00	226,355,442.29	8,764,457.71	96.27
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / улсын төсөв/	235,119,900.00	226,355,442.29	8,764,457.71	96.27
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,233,000.00	1,483,400.00	749,600.00	66.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,233,000.00	1,483,400.00	749,600.00	66.43
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	6.5	6.5	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.5	3.5	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2.0	2.0	-	100.00

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,955,800.00	37,955,800.00	0.00	100.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	37,955,800.00	37,955,800.00	0.00	100.0
210	Бараа, үйлчилгээний зардал	37,955,800.00	37,929,000.00	26,800.00	99.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,655,800.00	31,655,800.00	0.00	100.0
210301	Гэрэл цахилгаан	1,944,900.00	936,664.04	1,008,235.96	48.2
210302	Түлш, халаалт	29,710,900.00	30,719,135.96	-1,008,235.96	103.4
2106	Эд хогшил худалдан авах	6,300,000.00	6,273,200.00	26,800.00	99.6
210604	Урсгал засвар	6,300,000.00	6,273,200.00	26,800.00	99.6
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	26,800.00	-26,800.00	0.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	26,800.00	-26,800.00	0.0
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	26,800.00	-26,800.00	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	37,955,800.00	37,929,000.00	26,800.00	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,955,800.00	37,929,000.00	26,800.00	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	37,955,800.00	37,929,000.00	26,800.00	99.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын Соёлын төв нь тухайн орон нутгийн иргэний соёлын үйл ажиллагаа эрхлэх, бүтээл туурвих, соёлын ололт, үр шимийг хүртэх нөхцөлийг хангах, орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг сурталчлах, номын сангийн үйлчилгээ хүргэх чиг үүрэгтэй соёлын боловсрол олгох анхан шатны байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний

доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,562.1 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	
Авлага	1,466.9	2,314.5	847.6
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	29,916.2	34,646.2	4,730.0
Үндсэн хөрөнгө	607,757.9	598,618.2	-9,139.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>639,141.0</b>	<b>635,578.9</b>	<b>-3,562.1</b>
Өр төлбөр	69.9	671.7	601.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	639,071.0	634,097.2	-4973.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>639,141.0</b>	<b>635,578.9</b>	<b>-3,562.1</b>

Авлага дансны үлдэгдэл 2,314.5 мянган төгрөг болж 847,6 мянган төгрөгөөр өссөн нь албан хаагчид олгосон цалингийн урьдчилгаа болон нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай холбоотой авлага байна.

Үндсэн хөрөнгийн данс нь үлдэгдэл 598,618.2 мянган төгрөг болж 9,139.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 3,667.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, тайлант онд 12,807.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 671.7 мянган төгрөг болж 601.8 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн ашгийн татварын өр болон байгууллагад төлөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 635,578.9 мянган төгрөг болж 3,592.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улаангом сумын Соёлын төвийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 284,002.2 мянга, орон нутгийн төсвөөс 50,650.1 мянга нийт зарлагыг 334,652.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг улсын төсвөөс 46,692.8 мянган төгрөгөөр бууруулан 237,309.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 50,650.1 мянга нийт 287,959.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг улсын төсвөөс 1,956.5 мянга, орон нутгийн төсвөөс 12,694.3 мянган төгрөгөөр тус тус бууруулан, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2,233.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 233,869.8 мянга, орон нутгийн төсвөөс 37,955.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 2,822.5 мянга нийт 274,648.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 7,514.4 мянган, үйл ажиллагааны орлогын 1,339.1 мянга нийт 8,853.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 225,853.8 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702-Соёл урлаг 80101-Үйл ажиллагааны зардал	192,414.2	185,223.3	7,190.9	96.3%
2	71702-Соёл урлаг 80214-Уран бүтээл хийлгэх зардал	3,750.0	2,190.0	1,560.0	58.4%
3	71702-Соёл урлаг 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал	30,359.9	30,359.9	0.0	100.0%
4	71702-Соёл урлаг 81855-Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	8,595.8	8,582.2	13.6	99.8%
5	71702-Соёл урлаг 83603- Дээд шатны төсвөөс хуваарилсан	2,233.0	1,483.4	749.6	66.4%
6	71702-Соёл урлаг 80111- Төрийн өмчийн барилгын тогтмол	37,955.8	37,929.0	26.8	99.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

*/мянган төгрөг/*

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	1,010.0	Тайлант онд ашиглалтын зардал гараагүй байна.
2	Унаа, хоолны зардал	0.0	2025 онд 18,773.0 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
3	Сургалт, семинар	785.0	Няравын сургалтын төлбөрт 80, мянга, нягтлан бодогчийн сургалтын томилолтод 705.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	0.0	Хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зардал гараагүй байна.
7	Орон тоо	161,576.0	Тайлант онд 6.5 орон тоо ажиллахаар батлагдсанаас 6.5 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улаангом сумын Соёлын төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

#### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаангом сумын Соёлын төв нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай 12,996.3 мянган төгрөгийн бараа материал, 3,667.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүхий худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 297,736.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 2,977.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 290,486.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 2,904.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 2,323.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын Соёлын төвийн төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 171, хугацаа хоцроон байршуулсан 10, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.



**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Улаангом сумын Соёлын төвийн 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалаар номын санч Д.Алтанчимэгт өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг зөрүүтэй тооцон 1,112.1 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	1,112.1	1	1,112.1								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,112.1</b>	<b>1</b>	<b>1,112.1</b>								

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



2026 оны 02 сарын 25-ны өдөр



## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/16/А.2070413  
УВА-2026/0201/НЭ-СТА-7Ц.3

Улаангом

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаангом сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Улаангом сумын Соёлын төвийн 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалаар номын санч Д.Алтанчимэгт өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг зөрүүтэй тооцон 1,112,145 төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “албаны эрх мэдлээ хэтрүүлэх” Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.1-д “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3 дахь заалтад “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү олгосон тэтгэмж 1,112,145 /Нэг сая нэг зуун арван хоёр мянга нэг зуун дөчин тав/ төгрөгийг Улаангом сумын Соёлын төвийн даргаар ажиллаж байсан Д.Цэвээнчимэд, нягтлан бодогч Х.Өнөрдулам нараар төлүүлж МХГ-ын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Улаангом сумын Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Заяахүү, нягтлан бодогч Х.Өнөрдулам нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.АМАРМЭНД

М.БАТ АМГАЛАН

М.БАТСУУРЬ

